САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

НАЙМДУГААР САР 2019

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ДНБ
7.3%
2019 оны II-р улирлын байдлаар

ИНФЛЯЦИ
8.9%

ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ
2670.54 төг

ТӨСВИЙН АЛДАГДАЛ
14.43 тэрбум төг

ГАДААД ХУДАЛДАА
1295 сая АМ.ДОЛЛАР

ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3.6 ТЭРБУМ ДОЛЛАР

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
10.4%

НИЙТ ХАДГАЛАМЖ
13.7 ИХ НАЯД ТӨГ

МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
29.6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
925 ТЭРБУМ ТӨГ

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
11%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд:+6.1%
Инфляци: 2019 онд:+8.5%, 2020 онд:7.5%

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +7.1%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: http://bit.ly/2zsmvYo

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 8-р сарын байдлаар 14.43 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 85.5 хувиар, зарлага 84.7 хувиар тус тус буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 14.4 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 396 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 8.9 төгрөгөөр нэмэгдлээ.

Наймдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 206 төгрөг буюу 8.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 8.99 төгрөг буюу 0.34 хувиар нэмэгдэж 2670.54 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 3.6 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 12 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар тус тус өсчээ.

Инфляцийн түвшин 8.9%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 8-р сарын байдлаар өмнөх сараас 0.3 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар, оны эхнээс 5.4 хувь өсөв. Өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, эм тарианы үнийн дүн нэмэгджээ.



Гадаад худалдааны тэнцэл 1295 сая.ам доллар болов.

2019 оны наймдугаар сард нийт барааны эргэлт 9478.3 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 15.3, импорт өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 1295 сая ам.долларын ашигтай гарлаа.



8-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.1212.mn

Нийт хадгаламж 2019 оны 8-р сард 13.7 их наяд төгрөг болж өмнөх сараас 27 тэрбум төгрөг буюу 0.4 хувиар буурав. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 15.2 хувиар буюу 1736 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 10850.4 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 0.4 хувиар буурсан бол валютын хадгаламж 2944.3 тэрбум төгрөг болж өмнөх сараас 0.6 хувиар нэмэгджээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 79 хувь, валютын хадгаламж 21 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 15.2 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 11.5 хувийг эзэлж байна.

САРЫН ОНЦЛО

ДЭЛХИЙН БАНК МОНГОЛ УЛСАД 100 САЯ АМ.ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТ ОЛГОНО

- "Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөтөлбөр"-ийн хоёр дахь шатны 100 сая ам.долларын санхүүжилтийн гэрээнд хоёр тал гарын үсэг зурав. Тус санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газраас ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд олгож байгаа юм. Хөтөлбөрийн эхний санхүүжилт болох 120 сая ам.долларыг 2017 оны 12 дугаар сард олгосон. Харин хоёр дахь шатны 100 сая ам.долларыг Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хамтран олгож байна. Уг санхүүжилт нь төсвийн хөрөнгө оруулалттай төслүүдийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэх, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг сайжруулах, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, бизнес худалдааны орчинг сайжруулах, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэнэ.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНААС ЭЭЛЖИТ ТАЙЛАН ГАРАВ.

- Азийн Хөгжлийн банкнаас Монгол Улс, Азийн хөгжлийн төлвийн шинэчилсэн тайланг өнөөдөр танилцууллаа. Манай улсын эдийн засгийн өсөлт 2019, 2020 онд ялгүй саарах ч, тогтвортой хөгжлийг цогцлоосноор эдийн засгийн өсөлт тогтвортой байна гэж таамаглажээ. Дотоод эрэлт өсөж уул уурхай болон барилгын салбарууд тэлсэн нь 2019 оны эхний хагас жилийн эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлсөн. Харин жилийн сүүлийн хагаст БНХАУ-ын эрэлт саарч, дотоод эрэлт импортын өсөлтийг дэмжсэнээр эдийн засгийн өсөлт удаашрах аж. Ингэснээр 2018 онд 7.2 хувь байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2019 онд 6.7 хувь, 2020 онд 6.1 хувь болж буурах төлөвтэй байна.
  Инфляци 6 дугаар сарын дунджаар 8.1 хувь байсан бол өсөн нэмэгдэж буй дотоод эрэлт, хүнсний өндөр үнэтэй холбоотойгоор 2019 онд 8.5 хувь байхаар байна. 2020 онд эдгээр хүчин зүйлийн нөлөө харьцангуй бага байх тул инфляци 7.5 хувь болж буурна. 2019 оны эхний хагаст урсгал дансны алдагдал 10.2 хувь болж багассан ба 2020 онд импортын эрэлтээс үүдэлтэйгээр алдагдал нэмэгдэхээр байна. Монгол Улсын нэгдсэн төсөв 2019 оны эхний хагаст дотоодын нийт бүтээгдэхүүний 4.7 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарсан ба шинээр олгосон зээлийн өсөлт 5 хувьтай байснаар нийт зээлийн өсөлт буурсан. Чанаргүй зээлийн хэмжээ нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.6 хувьд хүрч өссөн байна.

Эх сурвалж:

1. *Статистикийн бюллетень, 8-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 8-р сар 2019 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*